

ӨСВӨР НАСНЫ СУРАЛЦАГЧДЫН ХҮМҮҮЖИЛ ХАНДЛАГАД ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА НӨЛӨӨЛӨХ НЬ

Х. Уранчимэг

“Нийгмийн ажил” хөтөлбөрийн магистрант

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

uugiiuranchimeg@gmail.com

Н. Нямдорж

Доктор (Ph.D)

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyataa89@gmail.com

Хураангуй: Монголын ирээдүй бол хүүхэд залуучууд юм. Хүний хөгжил гэр бүлээс эхэлдэг бөгөөд 3-6 насанд хүний суурь төлөвшлийн 60% нь бий болж төлөвшдөг. Боловсролын гол зорилго нь эх орондоо ухаалаг, ёс суртахууны зөв зан чанартай, эх оронч, өөдрөг, ажилсаг, эрхэлсэн үйлсдээ амжилт гаргах чадвартай үнэнч, амьдралд тулгарах саад бэрхшээлийг даван туулах тэнхээтэй залуу хойч үеийг бэлтгэх явдал юм гэж заасан байдаг. [1] АНУ, Япон зэрэг орнууд ч боловсролоо, хүнээ хөгжүүлэх, тэр тусмаа хүүхдийг хөгжүүлэх төлөвшүүлэх тухай байнга ярьсаар байна. Хүүхэд бүрийг эх хэл, үндэсний соёл, ёс уламжлалаа эрхэмлэсэн амьдрах ухаанд суралцах чадвартай зөв хүн болгох нь нийгмийн шаардлага болж байна. Эцэг эхчүүд гэр бүлийн орчинд хүүхдүүдийнхээ дуу хоолойг сонсож, мөрөөдөх, хөгжих боломж бололцоог нь бүрдүүлж, ирээдүйд эцэг эх болох талаарх ойлголтыг зөв өгөх хэрэгтэй.

Түлхүүр үг: гэр бүл, гэр бүлийн боловсрол, хүүхдийн эерэг хүмүүжил

УДИРТГАЛ

Судалгаанд оролцож буй суралцагчид болон эцэг, эхчүүдийн үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүрэг, хариуцлагын талаарх мэдлэг, ойлголтыг судлах зорилготой. Тиймээс суралцагчид, эцэг, эхчүүдийн хүүхэд хүмүүжүүлэх үүрэг, хариуцлагын хэр их мэдлэгтэй байгаа, хүүхдийг буруу үйлдэл хийхэд ямар хариу арга хэмжээ авдаг талаарх ойлголт, хандлагын асуудлыг хөндлөө. Энэхүү судалгаа нь нэг сумын ЕБС-н 6-12-р ангийн суралцагчид, эцэг, эхчүүдээс түүврийн аргаар авсан бөгөөд судалгааны үр дүнд суралцагчдын хүмүүжил, хандлагад гэр бүлийн харилцааны нөлөө гарч ирнэ гэж үзэж байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙ

“Гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг²⁵ хэлдэг бол хүүхэд гэж төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл хүнийг хүүхэд²⁶ гэнэ. 1999 онд шинээр батлагдсан Гэр бүлийн тухай хуульд заасан байсан “гэрлэлт нь 2 хүний тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ”²⁷ гэсэн байсныг 2016 оны 02-р сарын 05-ны өдөр “гэрлэлт гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ”²⁸ гэж заасан байдаг.

Ардчилсан нийгмийн нэг онцлог нь эрх чөлөө, ард иргэдийн эрх юм. Хүн бүр хуулиар олгогдсон эрхээ эдэлж үүргээ биелүүлэх хэрэгтэй. **Хүүхдийн эрхийн үндсэн зарчим**²⁹

Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална:

1. Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;
2. Төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;
3. Хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
4. Хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;
5. Хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангах үүргийг төдийлөн биелүүлж чадахгүй байна

Хүүхэд өөрийн гэнэн цагаан өртөнцөөр дамжуулан хүрээлэн буй орчин болон бусад зүйлсийн талаар сурч өдөр бүр шинэ зүйлстэй танилцаж байдаг. Гэр бүлийн оршиж буй хэлбэрийг:³⁰

1. Нуклеар буюу голлох гишүүдээс бүрдсэн гэр бүл
2. Өргөжсөн буюу хоёроос дээш үеийг хамарсан гэр бүл гэж ангилдаг.

Судалгаанаас харахад өргөжсөн, эсвэл хойд эцэг, эхтэй гэр бүл их байна. Тиймээс хүүхдийг зөв төлөвшүүлэхэд эцэг эх болон олон нийтийн оролцоо чухал үүрэгтэй. Тиймээс дараах 10 зүйлийг анхаарах шаардлагатай байна.³¹

²⁵ www.Legal.info.mn

²⁶ www.Legal.info.mn

²⁷ “ЛГБТИ-Хүний эрх”, (2018), Улаанбаатар хот

²⁸ www.Legal.info.mn

²⁹ www.legal.info.mn

³⁰ Т.Намжил, “Гэр бүл судлал” лекц, (2020), Улаанбаатар хот

³¹ “Хүүхдийн хөгжил” илтгэл, (2019), Улаанбаатар хот

Үүнд:

1. Хүүхдийн төлөвшилд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлсийг анхаарах

Хүүхдийн төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлсийг байгалийн болон нийгмийн гэж 2 ангилан үздэг. Байгалийн шалгарлыг туулах дээд зэргийн хөгжилтэй уураг тархи, мэдрэлийн систем бүхий амьд бодгал юм. Харин нийгмийн бүтээгдэхүүний хувьд болохын хувьд хүрээлэн буй байгаль болон нийгмийн орчин нэгэн чухал нөлөөг үзүүлдэг.

2. Хүүхдийн хүмүүжлийн доголдлыг анхаарах

Хүүхэд хүрээлэн буй газраасаа сайн болон муу үлгэр дууриал авч байдаг. Тиймээс шаардлагатай арга хэмжээг авч, зөв хүмүүжил олгож, зөв хүн болон төлөвшихөд нь туслах хэрэгтэй.

3. Өсвөр насны хүүхдийн зан аашны онцлогийг ойлгох

Өсвөр насны хүүхдүүд аливаад бие даан идэвх санаачлагчтай байхыг тэмүүлэн болж буй юмс үзэгдэлд дүгнэлт хийн шүүмжлэлтэй хандах чадвартай болж эхэлдэг.

4. Гэр бүлийн харилцааны үнэ цэнийг нэмэгдүүлж байх

Хүүхэд төрсөн цагаас эхлэн эцэг эхчүүд болон хүүхдүүдийн хоорондын харилцааг бататгаж гэр бүлийн гишүүддээ цаг зав гаргах хэрэгтэй.

5. Хүүхдээ аз жаргалтай байлгахад сургах

Хүүхдийг багаас нь бусдыг болон өөрийгөө хүндэлдэг эелдэг нэгэн болон өсөхөд тусалж

хийж байгаа зүйлийг нь дэмжиж, урамшуулах, хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогийг харгалзан бусадтай харьцуулахгүй байх

6. Эцэг эхчүүд өөрсдөө хүүхдийнхээ үлгэр дууриалал гэдгийг санах

Эцэг эхчүүд өөрсдийн хийж чаддаггүй эсвэл хийдэггүй зүйлсээ хүүхдээсээ шаардах нь утгагүй зүйл юм. Орчин үед утсаараа битгий тоглоод бай гэж хүүхдэдээ хэлдэг хэрнээ өөрөө байнга ухаалаг утсаа ашиглаж байдгаа анзаардаггүй эцэг эхчүүд бий.

7. Хүүхдийнхээ эрэлт хэрэгцээнд мэдрэмжтэй хандах

Эцэг эхчүүд хүүхдийнхээ авая гэсэн бүхнийг авч өгөх бус хэрэгцээт зүйлийг нь авч өгөх нь яагаад үүнийг авч болохгүйг тайлбарлаж байвал зүйтэй.

8. Хүүхдүүддээ дэлхийн дулаарал, хүн төрөлхтний тулгамдсан асуудлыг ойлгуулах

Хэрэв хүүхэд тань сургуульд орсон бол тэдэнтэй дэлхийн дулаарал, хог хаягдал, өлсгөлөн болоод бусад тулгамдсан асуудлын талаар ярьж ойлгуулах хэрэгтэй. Дэлхий дээр амьдарч буй хүн бүрд эдгээр асуудлууд хамааралтай бөгөөд гэрлээ унтраах, хогоо көв хаяхаас эхэлнэ.

9. Хүүхдүүддээ багаас нь бүтээлч байхад сургах


Хүүхдийнхээ баруун болон зүүн тархийг зэрэг хөгжүүлэх хэрэгтэй. Шинийг санаачлан багахан зүйлээр юм хийж чаддаг болгох нь чухал.

10. Хүүхдэдээ загас барих аргыг зааж өгөх


Эцэст нь эцэг эхчүүдэд зөвлөн хэлэхэд хүүхдэдээ бэлэн хоол өгч, бэлэнчлэх сэтгэлгээнд дасгахаас илүүтэй тэдэнд юуг яаж хийдэг арга ухааныг зааж өгөх нь зүйтэй юм.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2022 оны 12-р сард нэг сумын ЕБС-н 144 суралцагч, 60 эцэг эхээс түүврийн аргаар судалгаагаа авсан.




Суралцагчдын хувьд 14-16 насны суралцагчид их хамрагдсан бол эцэг эхчүүдийн хувьд 20-30 насны хүмүүс их хамрагдсан байна.



Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар суралцагчид болон эцэг, эхчүүд сайн мэдлэгтэй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Гэхдээ уламжлалт хүмүүжлийн аргыг төдийлөн хэрэглэхээ больсон гэж зарим эцэг, эхчүүд судалгаандаа дурдсан байна.



Судалгааг түүвэрлэн авчсан ч дийлэнх нь багш мэргэжилтэй хүмүүс оролцсон байна.



Хүүхэдтэйгээ ярилцаж, зөвлөдөг, анхны хүүхдээ өөрсдөө өсгөсөн эцэг эх их байгаа нь сайшаалтай байна. Эцэг эхчүүд хүүхдээ дараах аргаар өсгөж байна. Үүнд: зөвлөж, эерэг аргаар хүмүүжүүлэх зорилт тавьж, амьдралынхаа туршлагаар, уламжлалт ёс заншлаар, дэг журмыг танилцуулж, үлгэрлэж, бахархаж, ярилцаж, бие даалгаж, сургамжит өгүүллэгээр өсгөдөг гэж хариулсан. Хүүхдүүд эцэг, эхийнхээ сайн муу, үйлдлийг нь ихээхэн дуурайдаг.



Эцэг эхчүүд хүүхдээ загнах, тайлбарлах нь их байгаа бөгөөд өөрөө үлгэр жишээ бус байж хүүхдүүддээ шаардлага тавьж байгаа нь зохисгүй юм. Жишээ нь: эцэг эх өөрсдөө өглөө босоод ороо хураахгүй байж, хүүхдүүдээ ороо хураа гэж хэлж байна. Үгээр биш, үйлдлээрээ үлгэр жишээ байх хэрэгтэй. Гэр бүлийн дүрэмгүй учир гэрт хэн нэгэн нь давамгайлж, илүү их эрх эдэлж байна.



Хүүхдүүдийнхээ саналыг сонсож, секц дугуйланд явуулдаг эцэг эх олон байгаа нь сайн байна. Эцэг, эхчүүдийн бодлоор хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга гэж: хүүхэдтэйгээ ярилцах, зөвлөх, шаардлага тавих, өөрөө үлгэрлэх, уурлаж загнахгүй байх, аливааг тайлбарлах, ном үлгэр уншиж өгөх, монгол ёс заншлаас сургамжлах, зөв эрхлүүлэх, хүүхэдтэйгээ хамт тоглох, хамт гэрийн ажил хийх зэргийг хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга гэж үзэж байна.



Судалгаанаас харахад гэрлэсэн хүмүүс их байгаа боловч салсан гэр бүлийн тоо мөн адил өндөр байна.

8. Эцэг, эхчүүд хүүхдээ буруу үйлдэл хийвэл:

- хүүхэдтэйгээ ярилцдаг
- загнадаг
- ажил хийлгэдэг
- зоддог
- буруу хийсэн зүйлийн талаар хэлж ойлгуулдаг
- зөвлөгөө өгдөг гэж дийлэнх нь хариулсан.

Харин сурагчид ирээдүйд эцэг эх болоод үр хүүхдээ:

- хөгжил төлөвшилтэй хүн болгоно
- үе тэнгийн хүүхдүүдээс дор явуулахгүй
- хүүхдээ юугаар ч дутаахгүй
- өндөр боловсролтой болгоно
- эрүүл орчинд өсгөнө
- зөв хүмүүжилтэй болгоно
- хүүхдээ ойлгож, зааж, зөвлөнө,
- хүүхдээ хайрлаж, тусалж дэмжинэ,
- хатуужилтай өсгөнө
- хичээлд нь анхаарна
- бие бялдрыг нь хөгжүүлнэ
- монгол ёс заншлаа зааж өгнө
- хүүхдээ сонсоно
- хүүхэдтэйгээ найзууд шиг байна гэж сурагчид хариулсан байсан.

9. Суралцагчид эцэг эхчүүдээс дараах зүйлсийг хүсдэг:

- эрдэм номтой хүн болоход анхаарах
- зөв харьцах
- хааяа загнах
- хараа хяналт сайн тавих
- зөвлөх, дэмжих
- зодохгүй байх

- аливааг зөв ойлгуулах
- ээж, аав маань битгий салаасай гэж хүсдэг гэх мэт хариулсан.

10. Сургуулийн зүгээс эцэг, эхчүүдэд зориулан дараах үйл ажиллагааг зохион байгуулдаг:

- хүүхдийн тухай сургалт
- гэр бүлийн өдөрлөг
- жүжигчилсэн тоглолт
- эцэг, эхийн нэг өдөр
- эцэг, эхийн хурал зөвлөгөөн
- School police
- хүүхдийн аюулгүйн дүрэм
- спортын арга хэмжээ зохион байгуулдаг гэж сурагчид дүгнэсэн.

Сурагчид хичээлдээ хэр сайн болохыг эцэг, эхэд нь хэлэх, хүүхэддээ анхаарал хандуулахыг ойлгуулах, эцэг, эх, би хөгжөөнт тоглоом зохион байгуулах, шатрын тэмцээн зохион байгуулах, эцэг, эхчүүдийн дунд цэвэр бичгийн уралдаан зохион байгуулах, хөл бөмбөг, теннис болон сагсан бөмбөг зохион байгуулах ажил зохион байгуулж болно гэж сурагчид дүгнэсэн.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Суралцагчид өөрсдийн өсч байгаа гэр бүлийн орчноор ирээдүйгээ төсөөлж байгаа нь хязгаарлагдмал учир гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцааны талаар сургалт дутмаг гэж үзэж байна.
2. Эцэг эх, асран хамгаалагч нар үгээрээ биш, үйлдлээрээ үлгэрлэх хэрэгтэй байна.
3. Гэр бүл доторх хүүхдийн хүмүүжилд хүн бүр анхаарах цаг нь болсон байна.
4. Гэр бүлийн орчин, харилцаа хүүхдийн хүмүүжилд асар их нөлөөтэй байна

ДҮГНЭЛТ

Хүн бүхэн эцэг эх болдог учраас эртнээс ирээдүйнхээ төлөө санаа тавьж сайн эцэг эх болох гэж хичээж, гэр бүл төлөвлөлтөндөө анхаарч эхэлсэн бөгөөд маш сайн төлөвлөж хүүхдээ төрүүлж, хүүхдийнхээ хүмүүжлийн талаар ном авлагуудыг уншиж судалж байгаад хүүхдээ багаас нь зөв хүмүүжүүлж өсгөнө гэсэн сэтгэхүй аль хэдийн төлөвшсөн байна. Мөн хүүхэдтэйгээ байнга ярилцаж, тэдэнтэй ойр дотно байх бөгөөд хань, үр хүүхдээ хайр халамжаар дутаахгүй сайн эцэг эх болно гэсэн бодолтой байхад зарим нь хүүхдэд хайргүй, эцэг эх болоход би өөртөө итгэлгүй байдаг, хүнтэй суух дургүй гэх мэт шалтгаанаас болоод эцэг эх болох хүсэлгүй гэдгээ илэрхийлсэн байсан. Үүнээс харахад өсч байгаа орчин маш их нөлөөлж байгаа учир мэдлэгийг нь нэмсэн сургалт зохион байгуулах хэрэгтэй байна. Гадаадын орнуудын гэр бүлийн

доторх хүүхэд хүмүүжлийн зарим арга нь Монголын онцлогт тохирохгүй байна. Тиймээс уламлалт аргаа хэрэглэх нь хүүхдийг аюулгүй байдлаас хамгаалж чадаж байна. Тухайлбал: ГССҮТ-д бага насны хүүхдүүдийг унагаасан, түлсэн дуудлага их ирдэг. Тухайн үед хүүхдийг бүсээр уяж хүүхдийн тоглох орчинг бүрдүүлж, аюултай зүйлсийг нь авч, хараа хяналт сайн байсан бол бид энхрий бяцхан үрсээ гар, хөл, биеийг нь түлж өвтгөхгүй л байсан.

Судалгаанд оролцсон эцэг, эх, суралцагчид бүгд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар мэдлэгтэй байгаа нь сайн боловч хүүхдүүдтэйгээ ярилцдаггүй, зөвлөж тусалдаггүй эцэг эхчүүд их байна. Мөн гэр бүлийн орчин, харилцаа нь хүүхдийн хүмүүжилд асар их нөлөөтэй байгаа бөгөөд хүүхдийн зан ааш эвдрэх, буруу зан үйлд татагдах нь их байна.

НОМ ЗҮЙ

[1] *Е.Дюррант, “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” (2010), Улаанбатаар хот*

[2] *“Бага насны хүүхдийн хөгжил, хамгаалал” (2017), Улаанбаатар хот*

[3] *“Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”(2017), Улаанбаатар хот*

[4] *“ЛГБТИ-Хүний эрх”, (2018), Улаанбаатар хот*

[5] *Т.Намжил, “Гэр бүл судлал” лекц, (2020), Улаанбаатар хот*

[6] *“Хүүхдийн хөгжил” илтгэл, (2019), Улаанбаатар хот*

[7] *Монгол улс. Гэр бүлийн тухай хууль 1997 он*

[8] *Монгол улс. Хүүхдийн эрхийн тухай хууль. 2017 он*

[9] *Монгол улс. Хүүхэд хамгааллын тухай хууль. 2017 он*